



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/91

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төр сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жонон Ханчин Гэгээнтэн Хэнтий аймагт айлчилж нутгийн сүсэгтэн олонд ном хурж, ерөөл айлдахад зориулж хүндэтгэл үзүүлж, хөрөнгө зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 1009000 /нэг сая есөн мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2017 оны
03 дугаар сарын 07 өдрийн
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1.	Хоол	15 хүн	20,000	300,000
2.	Мөнгөн аяга	1 ш	180,000	180,000
3.	Ааруул	3 кг	12,000	36,000
4.	Цэвэр ус	10 ш	450	4,500
5.	Айраг	5 л	5,000	25,000
6.	Хадаг	1ш	3,500	3,500
7.	Аяганы бичвэр		10,000	
8.	Зэд		450,000	
		Дүн		1,009,000